



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТУГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/42

Улаанбаатар хот

Г Унэлгээний хороо байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТУГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхэд шаардагдах нэг наст цэцгийн үрсэлгээ авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ш.Сүхбаатар

Хангамж, аж ахуйн албаны дарга

Гишүүд:

Д.Батцэцэг

Ногоон байгууламжийн ахлах мэргэжилтэн

Ц.Минжин

Баруун салбарын ахлах нягтлан бодогч

Н.Эрдэнэцэцэг

Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

А.Оюунчимэг

Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн эдийн засагч

2. Холбогдох хууль тогтоомжийг мөрдэж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Ш.Сүхбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа дэмжих асуудал хариуцсан Орлогч дарга /С.Майнбаяр/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭНХСАЙХАН

2130300083  
БААГИЛГААНДОСХ

